

## НОМ ӨГҮҮЛЛИЙН ШҮҮМЖ

**ХЯТАДЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТУХАЙ  
ВЬЕТНАМ СУДЛААЧДЫН НЭГЭН БҮТЭЭЛ**

(шүүмж)

Вьетнамын нийгмийн шинжлэх ухааны хорооны Ази, Номхон далайн хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн “Маогаас Дэн Сяопин хүртэлх үеийн Хятад орон” (Ханой, 1984. 302 х) хэмээх ном баялаг баримтад тулгуурлан Хятадын нийгэм-улс төрийн зарим гол эдрээтэй асуудлыг тухайлан авч шинжлэн, түүнд аль болох тодорхой дүгнэлт хийхийг хичээснээрээ онцлог юм. Номын агуулга нь Хятадын өнөөгийн үзэл суртал, нийгэм-эдийн засаг, гадаад улс төрийн бодлого, соёлын асуудлыг хамарч байна.

Маоизм бол Хятадын нийгэм-улс төрийн өвөрмөц нөхцөлд үүсч бий болсон жижиг хөрөнгөтний оппортунист урсгал бөгөөд Хятадын өнөөгийн эрх баригчдын үзэл сурталд маоизм аль хир нөлөөтэй байгаа талаар хөрөнгөтөн орны болон социалист орны хятад судлаачдын санал нэгдмэл биш байгаа билээ. Учир нь Маог нас нөхчсөний дараа “Соёлын хувьсгалаар” шийтгэгдсэн олон хүмүүсийг цагаатгаж, “Соёлын хувьсгал”-ын үеийн бүх ялт ажиллагааг хэвлэлд ил шүүмжилж, маогийн үзэл баримтлалд зарим нэг засвар хийж байгааг Хятадад маоизм үгүй болж байгаа мэтээр хөрөнгөтний зарим судлаачид үзэж байна.

Вьетнамын судлаачид Хятадын өнөөгийн гадаад, дотоод бодлогын зарим өөрчлөлтийг судлан шинжлээд, “маоизм Хятадын өнөөгийн эрх баригчдын үзэл суртлын гол агуулга хэвээр байгаа бөгөөд шинэ нөхцөлд тохируулан зөвхөн түүний өнгө зүсийг “шинэчилж байна” гэсэн дүгнэлт хийж байна. (х.75)

Маогийн үзэл санаа, маоизмын зарим баримтлалд засвар хийж “шинэчилж” байгаагийн учрыг тайлбарлахдаа, Ази, дэлхий дахинд ноёрхох гэсэн Хятадын их гүрний маоист гадаад дотоод бодлогын стратегийн зорилтыг аль болохоор хэрэгжүүлэх гэснээс үүдэн гарсан болохоос маоизмын эсрэг чиглэсэн зүйл биш юм гэжээ. (х75-78)

Ах дүү социалист орнуудын хятад судлаачдын анхаарлыг гойд татаж байгаа нэг зүйл бол Хятадын өнөөгийн эдийн засгийн шинэчлэлтийн асуудал юм.

Өгүүлэн буй номын бараг гуравны хоёр хувийг энэ асуудалд зориулсан нь Вьетнамын судлаачид Хятадын бодлогын хамгийн гол зангилаа асуудал болох Хятадын эдийн засгийн бодлогыг судлахад ихээхэн анхаарч байгааг харуулж байна.

Хятадын эдийн засгийн потенциалыг нэмэгдүүлэх зорилгоор сүүлийн үеийн Хятадын эрх баригчид эдийн засгийн бодлогод зарим өөрчлөлт

хийж эхэлсэн билээ. 1978 оны 12-р сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны III бүгд хурлаас Хятадын эдийн засгийн бодлогод гүнзгий нөлөөлж агсан “хэт зүүний” бодлогыг албан ёсоор анх шүүмжилсэн бөгөөд энэ үеэс эхлэн эдийн засгийн шинэ арга хэмжээг эрчимтэй авсан юм. Юуны өмнө “хуарангийн социализмын” хэт төвлөрсөн удирдлагын системд өөрчлөлт хийж, төв орон нутгийн үйлдвэрүүдийн нэгжид аж ахуйг бие даан хөтлөх эрхийг өргөжүүлж, зах зээлийг чөлөөтэй болгон, хувийн жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гадаадын капиталыг хөнгөлттэй оруулах, хөдөө аж ахуйд “хариуцлагын систем” гэгчийг хэрэгжүүлэх нэрээр хувийн өмчийн хэлбэрийг дэмжих зэрэг арга хэмжээ авч байгаа юм. Нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж, ард түмний материаллаг болон оюун санааны өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээний хангамжийг сайжруулахын тулд ах дүү социалист орнууд ч аж ахуйг удирдах механизмыг боловсронгуй болгох үйл ажиллагааг хийж байгаа билээ. Социалист орнуудад хийгдэж буй аж ахуйн системийн шинэчлэл нь социалист аж ахуйн системийг бэхжүүлж, социалист аж ахуйг удирдах зарчмуудыг улам боловсронгуй болгоход чиглэж байна. Гэтэл Хятадад хийгдэж байгаа эдийн засгийн “шинэчлэл” нь ах дүү социалист орнуудынхаас үндсэн ялгаатай байгаа бөгөөд төлөвлөгөөт удирдлагыг сулруулж, социалист төлөвлөлтийн зарчмуудыг орхиж, капиталист аж ахуйн удирдлагын аргыг шохоорхон хэрэгжүүлж, улсын социалист аж ахуйн системийг аажмаар эвдэн бусниулах чиглэлээр явж байгаа ажээ. 1981 оны 6 дугаар сарын 27-нд болсон ХКН-ын Төв хорооны 5-р бүгд хурлын баримт бичигт “социалист үйлдвэрлэлийн харилцааны хөгжилд тогтсон нэг загвар байж болохгүй, бидний зорилт бол өөрийн орны үйлдвэрлэлийг цаашид хөгжүүлэхийн тулд түүний хөгжлийн үе шатанд тохирсон үйлдвэрлэлийн харилцааны тодорхой хэлбэрийг буй болгох хэрэгтэй” гэж заасан байна. (х.112) Үйлдвэрлэх хүчин мөхөс, үйлдвэрийн хөгжлийн тэнцвэртэй биш байдал зэрэг нь хятадын өнөөгийн онцлог шинж бөгөөд эдийн засгийн ийм нөхцөлд өмчийн олон хэлбэр байх ёстой гэж хятадын эрх баригчид үзэж байна. (х.112)

Чухамхүү энэ үүднээс Хятадад хувийн өмчийн хэлбэрийг хөхүүлэн дэмжиж байгаа ажээ.

Зөвхөн хот суурин газрын хувийн үйлдвэрлэл эрхлэгч өрхийн тоо 1980 онд 220 мянга байсан бол 1981 онд 1.13 сая, 1982 онд 1.47 сая, 1983 онд 1.7 сая болж өссөн бөгөөд хөдөө аж ахуйн чанартай хувийн үйлдвэрлэл эрхлэгчдийг үл оролцуулсан хот хөдөөгийн хувийн үйлдвэр эрхлэгч эрхийн тоо 1984 онд 7.5 сая болжээ. (х.114)

Хятадад үндэсний хөрөнгөтнүүдийн эрх дархыг сэргээж хувийн үйлдвэр байгуулах эрх олгож байгаагийн зэрэгцээ гадаадын капиталыг оруулах “үүд хаалга” гэж нэрлэгдсэн эдийн засгийн тусгай районыг олшруулж байна.

Үүнийгээ Хятадын эрх баригчид “төрийн урт удаан хугацааны чиг шугам”, “Намын стратегийн шинжтэй шийдвэр хэмээн зарлаж (х.45) түүгээр ч барахгүй социалист байгуулалтын онол, практикт” шинэ хувь нэмэр оруулж байгаа” мэтээр бичиж байна. Хятадын эдийн засгийн шинэчлэл нь сүүлийн 20 жил уналтын байдалд орсон аж ахуйг хөл дээр нь босгох, эдийн засгийн бодлого дахь зарим субъектив алдааг засаж залруулахад зарим талаар нааштай алхам болж байгаа боловч социализмын эдийн засгийн үндсэн зарчмуудыг засварлахыг оролдож, Хятадын үндэсний онцлогийг товойлгон “Хятадын онцлог бүхий социализм”-ыг хэрэгжүүлэхийг санаархахын хамт,

хэт зүүний хандлагаас барууны хандлагад хальтран орж байгаагаараа аюултай юм гэж вьетнамын судлаачид үзэж байв. (х.78-82, 117)

Хятадын удирдлага дахь прагматик бүлэглэлийн аюултай шинж нь эдийн засгийн ашиг гарч байвал эдийн засгийн ямар ч хэвшлийг дэмжиж, социализмын эдийн засгийн үндсийг золионд гаргахад бэлэн байна. Энэ хандлага цаашид удаан үргэлжилбэл улс ардын аж ахуйн төвлөн удирдах ленинч зарчим, ангийн эрх ашгийг бүрмөсөн хөсөрдүүлж, Хятадын нийгэм-эдийн засгийн бүтцийг өөрчлөхөд хүргэж мэдэх юм. Нөгөөтэйгүүр Хятадын нийгмийн зөрчил, тухайлбал жижиг хөрөнгөтөн, түүнд хөлсөөр ажиллагчдын хооронд, мөн шинээр төрөн гарч буй чинээлэг тариачид, ядуу, дунд тариачдын хоорондын зөрчил улам гүнзгийрэх нь зайлшгүй гэжээ. (х.118) Мөн удирдлагын дунд зөрчил гүнзгийрч мэдэх юм. Хятадын удирдагчид аж ахуйн удирдлагын системийг сонгохдоо санал зөрөлдөөнтэй хэвээр байна. Нэг хэсэг нь дээд зэргээр төвлөрсөн шууд удирдлагын системийг, нөгөө хэсэг нь нэлээд бие даасан удирдлагын системийг, гурав дахь нь хувийн аж ахуйн механизмыг дэмжиж байна. Эдгээр чиглэлийнхний тэмцэл ба зохицлын үр дүнд өнөөгийн хятадын аж ахуйн механизм буй болжээ. Гэвч эдгээр чиглэлийн тэмцэл дуусаагүй цааш үргэлжилж байгаа бөгөөд сүүлийн чиглэл нь улам давамгайлах хандлагатай байгааг дурджээ. (х.143)

Вьетнамын судлаачид Хятадын гадаад бодлогод үндсэн өөрчлөлт гараагүй байна гэсэн дүгнэлт хийжээ. (х.196) Хятадын удирдлага эрин үеийн тухайд шинжлэх ухааны үндэстэй, ангич тодорхойлолт өгөхгүй байгаа бөгөөд өнөөгийн олон улсын харилцааны үндсэн зөрчлийг хоёр системийн хоорондын зөрчил биш, харин “Хоёр хэт их гүрний өрсөлдөөн” мэтээр тайлбарласаар байна. (х.192)

Тухайлбал орчин үед олон улсын байдал хурцдаж байгаагийн бурууг АНУ, ЗХУ хоёрт нэг адил тохож байна. Үүнээс үндэслэн “Энх тайвны төлөө тэмцэл “гэгчээ” дэлхийн хоёр их гүрний эсрэг тэмцэл” гэгчтэй холбож байна.

Хятадын эрх баригчид империалист хүчинтэй улс төр, эдийн засгийн харилцаагаа өргөжүүлсээр байгаа хирнээ тэднээс ямар нэг хэмжээгээр хөндий байгаа мэт дүр үзүүлж байна. энэ нь “гурав дахь ертөнцийн” удирдагч, “бие даасан гурав дахь хүчний” төв болон гэсэнтэй нь холбоотой гэжээ. (х.195)

Хятадын эрх баригчид ах дүү социалист орнуудыг “найрамдалт орон”, хоёр талын “харилцааг сайжруулж байгаа орон”, “эсэргүүцэж байгаа боловч хязгаарлагдмал хэлэлцээ хийж болох орон”, дайсагнан үзэж ганцаардуулах орон” гэх мэтээр ялгаварлан үзэж байгаа нь социалист хамтын нөхөрлөлийг задлан бутраахад чиглэгдэж байна. (х.193)

Тэд социалист орнуудын хоорондын харилцаанд ямар ч онцгой хэлбэр байхгүй хэмээн тунхаглаад үнэн хэрэгтээ ах дүү орнуудын харилцааны пролетарийн болон интернационалын зарчмыг үгүйсгэж байна. Түүнчлэн социалист хамтын нөхөрлөлийн дотор “эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн” маягийн юм бий болгохыг эрмэлзэн, тэгснээрээ Зөвлөлтийн эсрэг, Вьетнамын эсрэг чиг шугамдаа ах дүү орнуудыг төвийг сахих байранд түлхэн оруулахыг оролдож байна гэжээ. (х.193) Гадаад бодлогын тухай ярихдаа марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын тухай дурсахаа болиод удсан байна. Түүний оронд “тусгаар тогтнол, эрх тэгш байдал, харилцан хүндэтгэх,

бие биеийн дотод хэрэгт үл оролцох” гэх мэтийн ерөнхий зарчмуудыг салангид байдлаар ярьсаар байна гэжээ. (х.87)

Хятадын удирдагчид сүүлийн жилүүдэд гадаад бодлогынхоо зарим арга тактикийг өөртөө ашигтайгаар өөрчилж байгаа хирнээ Энэтхэг-Хятадын хойгийн гурван орны явуулж байгаа бодлогодоо стратеги, тактикийн ямар ч өөрчлөлт хийсэнгүй. (х.196)

Хятадын коммунист намаас дэлхийн коммунист хөдөлгөөнтэй харилцаж байгаа байдлыг ажиглавал 60-аад оныхоо арга барилыг өөрчилсөн нь илт байна. Коммунист намуудаас холбоогоо тасалж, маоист задлан бутаргагч бүлэглэлийг байгуулан, олон улсын коммунист хөдөлгөөний эсрэг ил тэмцэж байсан хуучин арга барил нь бүтэлгүй болмогц зарим коммунист намуудтай аль болохоор холбоо тогтоож, түүгээр дамжуулан коммунист хөдөлгөөнд нөлөөлөхийг хичээх болжээ. (х.195) Үүнтэй холбогдуулан Маогийн үеийн маоизм бодит социализмын эсрэг, олон улсын коммунист хөдөлгөөний эсрэг ил тэмцэл явуулж, тэгснээрээ өөрийгөө бүхэнд илчилж байсан бол Дэн Сяопиний үеийн маоизм нь дэлхийн социализм, олон улсын коммунист хөдөлгөөнийг илт заналхийлэхээ больж, өөрийн орны болон дэлхийн олон нийтийг төөрөгдүүлэн, арга мэхээ улам нарийсгаж байна гэж тэмдэглэжээ. (х.87)

Хятадын утга зохиол, урлагийн сүүлийн үеийн байдлын талаар бичсэн хэсэгт Хятадын удирдлагаас урлаг, утга зохиолын талаар явуулж буй бодлогын үндсэн чиг шугамыг тодорхойлохдоо: “Уран бүтээлчдийн бүх авьяас хүчийг “дөрвөн шинэчлэлд” дайчлахад чиглэж байна” гэжээ. (х.250-251)

Дэн Сяопиний үеийн Хятадын урлаг, утга зохиолд “соёлын хувьсгалын үеийн алдаа завхралыг илчилсэн шүүмжлэлт реализмын чиглэлийн уран бүтээл олноор гарах болжээ. Хятадын удирдлага ч маогийн үеийн алдаа завхралыг илчлэн шүүмжилсэн уран бүтээлийг олонтаа хөхүүлэн дэмжиж байлаа. Гэвч энэ чиглэл хэт газар авч, бүр сүүлдээ Дэн Сяопиний бодлогын эсрэг хандаж магадгүй болоод ирэхийн хамт таслан зогсоох арга хэмжээ авч эхэлжээ. Үүний гол зорилго нь Дэн Сяопиний бүлгийн бодлогыг эсэргүүцсэн аливаа хандлагыг тас цохиж, урлаг утга зохиолын нөлөөлөх хүчийг мөнөөхөн “дөрвөн шинэчлэл” гэгчдээ ашиглахыг л хичээсэн хэрэг юм. (х.139) Ийм нөхцөлд зарим зохиолч, уран бүтээлчид цөхрөн гутарсан өнгө аястай уран бүтээлийг шохоорхох болжээ. Аливааг илчлэн шүүмжлэхгүй иймэрхүү зохиол бүтээл Дэн Сяопиний бүлгийнхэнд илт харшлахгүй байгаа ч гэсэн “дөрвөн шинэчлэлийн” зорилгод үл итгэсэн байдлын зарим илрэлийг тэвчихгүй байна.

Ази, Номхон далайн хүрээлэнгээс гаргасан эл ном нь Хятадын өнөөгийн нийгэм-эдийн засаг, соёлын амьдрал, гадаад, дотоод улс төрийн бодлогын мөн чанарыг гүнзгий ойлгоход зохих нэмэр хандив болж байна.

С.Дашцэвэл